

ШИЙДЛИЙН ТАНИЛЦУУЛГА

aruba
Instant on

Wi-Fi хурдны дээд хязгаарыг мэдрүүлэх **Aruba Instant On**



Кофе шоп, ресторан, дэлгүүр гэх мэт худалдаа, үйлчилгээний газрууд, амралтын газар, зочид буудал, оффис, тэр бүү хэл гэртээ ч бид байнга Wi-Fi ашигладаг.



Эдгээрт хаана ч байсан ижил үйлчилдэг нэг дүрэм байдаг. “Хурдтай, найдвартай Wi-Fi нь уйтгартай уур амьсгалыг гайхалтай болгон хувиргаж чаддаг.” Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хувьд аль нэгэн газраар үйлчлүүлэхдээ чөлөөтэй Wi-Fi ашиглан ойр дотнынхоо хүмүүстэй цаг алдалгүй мэдээллээ солилцох боломжтой байх нь таатай байдаг бөгөөд стори, пост хийх зэргээр таны бизнесийг ч мөн сурталчилсаар байдаг.

Тасралтгүй, хурдтай Wi-Fi-тай байх нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, илүү хурдтай ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг. Уян хатан байдал (хөдөлгөөнт байдал), шаардлагатай аппликэйшн нь тасралтгүй ажиллах боломжтой байх зэрэг нь ажилчдад байнга холбоотой байж, үр дүнтэй ажиллах боломжийг олгоно. Мэдээж таны ажилчид болоод хэрэглэгчид сэтгэл хангалуун байвал, та хамгийн чухал зүйлдээ буюу бизнестээ бүрэн анхаарах боломжтой.

Aruba Instant On-ийн Access Point-уудтай танилцана уу.



AP11D

ШИРЭЭНИЙ / ХАНЫН



AP11



AP12

ДОТОР БАЙРЛАХ



AP15



AP17

ГАДНА БАЙРЛАХ

From blazing to amazing!

Өндөр хурд/хүчин чадал бүхий Wi-Fi-д аюулгүй хандах боломжийг олгох Aruba Instant On шийдлийг танд хямд үнээр санал болгож байна.

Дотор болон гадна орчинд, түүнчлэн жижиг болон гэр оффист ашиглах зориулалттай зэрэг төрөл бүрийн загвараас өөрийн хэрэгцээнд нийцүүлэн авах боломжтой.



БОДИТ ХҮЧИН ЧАДАЛ

Хэзээ ч мэдэрч байгаагүй хурдтай интернэт, аппликэйшний ажиллагаа



ЧӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЛЭЭ

Smart Mesh технологийн тусламжтайгаар таны байгаа орон зайг бүхэлд нь хамарна




17 ЖИЛ НОТЛОГДСОН ИННОВАЦИ

Энтерпрайз болон жижиг дунд байгууллагад ашиглагддаг батлагдсан технологи



Aruba Instant On Гар утасны аппликэйшн

Сүлжээг асааж, ажиллуулах, удирдах, хянахад маш хялбар. iOS болон Android үйлдлийн систем бүхий ухаалаг төхөөрөмж байхад л та Instant On ашиглан 1,2,3 тоолохын дотор сүлжээгээ тохируулах боломжтой.





ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ БИЗНЕС

Зочдын болон ажилчдын Wi-Fi сүлжээг хялбар тохируулах боломжтой



AP11

Жижиглэн худалдааны бизнес эрхлэгчдийн хувьд интернэт холболт, аюулгүй байдал зэрэг нь үйл ажиллагааных нь гол шаардлага байдаг. ПОС систем, цалингийн тооцоо, нөөцийн удирдлага, зочдод хүртээмжтэй байх зэрэг нь бизнес явуулахад шаардлагатай байдаг зүйлс бөгөөд дэлгүүр доторх утасгүй сүлжээ нь ажилчид болоод үйлчлүүлэгчдийн аль алинд нь нэн чухал байдаг.

Хувцасны жижиг дэлгүүр, үл хөдлөх хөрөнгийн газар эсвэл шүдний эмнэлэг зэрэг өөр эдгээртэй ижил төстэй байгууллагуудад Aruba Instant On AP11 нь төгс тохирно. Үр ашигтай, удирдахад хялбар уг Wi-Fi шийдэл нь өнөөдрийн бужигнасан худалдааны орчин дахь мобайл, IoT болон аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан шийдэл юм.




ЗОЧЛОХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зочид болон ажилчдад төгс нийцсэн



AP12



AP11D



AP17

Зүгээр л нэг удаан интернэт, муу Wi-Fi зэрэг нь 5 одтой зочид буудлыг 4 одтой, бүр түүнээс доош үнэлгээтэй болгодог. Хэрэв та жижиг дэн буудал эсвэл boutique зочид буудал ажиллуулдаг бол мэдээж танай зочид хурдтай, аюулгүй, хүссэнээрээ тохируулах боломжтой утасгүй интернэтийг шаардах болно.

Aruba Instant On AP11D, AP12 болон AP17 зэрэг загварууд нь тасалгаан дотор болон гадна тасралтгүй ажиллах шаардлага бүхий орон зайд тохиромжтой бөгөөд, өрөөн дотор ч тасралтгүй ажиллах Wi-Fi-ийг хүргэдэг. Үр ашиг бүхий уг шийдэл нь танай ажилчид болон зочдыг сэтгэл хангалуун байлгах болно. Түүнчлэн энгийн програм хангамжийн тохируулгаар Netflix, хяналтын камерууд, гол системүүдээ болон бусад үйл ажиллагааны системүүдээ ажиллуулаарай.



МЭРГЭЖЛИЙН ОФФИС

● Өндөр нягтшил бүхий Wi-Fi хэрэглээнд тохирсон



AP15

Дөнгөж бизнесээ эхэлж байх үед цагаас тань хугаслах мянга мянган шийдвэр гаргалтууд тулгардаг. Хэрэв та өндөр хүчин чадалтай зөөврийн компьютер, хэвлэгч, хувилагч гээд л шаардлагатай техникийн нөөцөө бэлтгэсэн бол та амжилтын сууриа тавьж чадсан гэсэн үг юм. Үүн дээр нэмээд та интернэтэд холбогддог төхөөрөмжүүдийнхээ ажиллагааг өндөр хүчин чадал бүхий утасгүй сүлжээгээр шийдвэрлээрэй.

Aruba Instant On AP15 нь хөдөлгөөнт байдлыг эрхэмлэдэг, нягтшил өндөртэй ажлын байранд тохиромжтой шийдэл бөгөөд энэ нь өсөн нэмэгдэх endpoint, клауд аппликэйшн болон их хэмжээний дата илгээх боломж зэрэг гүйцэтгэлийг хүргэснээр танай ажилчид болон төхөөрөмжүүд хамгийн сайнаараа ажиллахад тусална. Шаардлагатай бүх аюулгүй байдлын боломжуудыг агуулсан тул ажил үүргээс нь үл хамааран бүх хүний датаг аюулгүй хамгаалах болно.

Яагаад Aruba Instant On-ийг сонгох хэрэгтэй вэ?

Өнөөдрийн өрсөлдөөнтэй дижитал ертөнцөд тэмцэж үлдэхийн тулд жижиг бизнесүүд томоохон байгууллагуудтай адилаар инновац бүхий шийдлүүдийг нэвтрүүлж, эрсдэлийг бууруулж, зардал хэмнэж, үнэ цэнэ бүтээх замаар хэрэглэгчдийнхээ итгэлийг олж авч байна. Ядаж л танай утасгүй интернэт таны санааг зовоодоггүй байх хэрэгтэй.



Aruba Instant On нь ямар ч жижиг бизнесийн шаардлагад нийцэх сүлжээний аюулгүй байдал, хялбар тохиргоо, удирдлагын програм хангамж, дэлхийн жишигт нийцсэн хүчин чадал зэргийн хослолыг танд хүргэх болно. Түүнчлэн танд боломжит хамгийн сайн хэрэглэгчийн болоод мэдээллийн технологийн туршлагыг хүргэнэ. Та шинээр бий болж буй аппликэйшн болон IoT өсөлтийг дэмждэг, зардлын хувьд үр ашигтай, өргөтгөх боломж бүхий дээд зэргийн чанартай төхөөрөмж болон програм хангамжтай болох юм.

ARUBA КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ТҮНШ АЙ ТИ ЗОН КОМПАНИ

aruba
Instant on

Since 1997
ITzone[®]
Accelerate Your Success

 www.itzone.mn/page/aruba-instant-on

 7731-2424

 crm@itzone.mn